


63.3(5Моч)
Б 823



БНМАУ
ӨМНӨГОВЬ АЙМАГ

(Танилцуулга)

Даланзадгад хот.

Өмнөговь аймаг анх 1931 онд БНМАУ-ын Засгийн газрын шийдвэрээр хуучин Сайн ноён хан, Түшээт хан хоёр аймгийн зарим хушуудыг оролцуулан шинээр байгуулжээ.

1942 онд Дундговь аймаг байгуулагдахад зарим сумд нь тийшээ шилжиж нутаг дэвсгэрийн нилээд өөрчлөлт орсон юм. Одоогийн оршиж байгаа нутаг нь хуучин феодалын засаглалын үеийн Сайн ноён хан аймгийн Чүлтэм бээсийн хушуу, Түшээт хан аймгийн Түшээт вангийн хушуу, Эетэй оээлийн хушуу, Мэргэн вангийн хушууны хагасыг эзлэж байгаа юм. Энэ нутгийн ард түмэн эдгээр цөөн тооны феодалын хамжлага бийлаа.

Хувьсгалаас өмнө говийн ард түмэн улс төрийн өчүүхэн эрх мэдэлгүйгээр гадаад дотоодын хэдэн давхар дарлалын дор талхигдаж байлаа. Тэд дотоодын феодалуудад хамжлагын ажил хийхийн хамг бүтээгдэхүүний ба мөнгөн татвар төлдөг байв. Говь нутгийн ард түмний эрхэлдэг гол аж ахуй нь байгалийн эрхшээлд захирагдсан бүдүүлэг арга ажиллагаатай хувийн, жижиг тархай бутархай нүүдлийн мал аж ахуй байсан бөгөөд цөөн тооны гар урчуудыг өс оруулбал үйлдвэрлэлийн ямар ч салбар байсангүй. Ердийн хөсгөөс өөр тээвэр, дардан замаас өөр зам харилцаа байгаагүй. Ард түмний өдөр тутмын хэрэгцээг хангах, улсын чанартай худалдааны байгууллага байсангүй. Гагцхүү гадаадын шунахай худалдаачид, мөнгө хүүлэгчид ноёрхож байлаа.

Ардын соёл гэгээрэл, эрүүлийг хамгаалах байгууллага огт байсангүй. Шарын шашны 60 орчим сүм хийдэд хэдэн мянган эрчүүд шавилан сууж

нийгмийн тустай хөдөлмөрөөс чөлөөлөгдөж бай-
жээ. Хэдхэн тооны феодалас өөр үндэснийхээ
хэл бичгийг мэддэг хүн бараг байгаагүй юм.
Орос оронд мандсан Октябрийн социалист их
хувьсгалын үр дүнд манай ард түмний өмнө жар-
галант шинэ амьдралын зам нээгдсэн билээ. Ма-
най говийн ард түмэн ч эрх чөлөө, тусгаар тогт-
нолынхоо төлөө тэмцсэн ардын хувьсгалын үйл
хэрэгт идэвхтэй оролцож байсан юм.

1921 оны партизан, ардын хувьсгалын ялалтын
төлөө бүх амьдралаа зориулсан Нанзад баатар,
1932 онд болсон хувьсгалын эсэргүү дайснууд-
тай эрэлхгээр тэмцэж эх орон ард түмнийхээ
үйл хэргийн төлөө чин үнэнчээр зүтгэж байгаад
дайсны гарт хорсолтойгоор амь үрэгдсэн МХЗЭ-
ийн гишүүн эвлэлийн үүрийн анхны даргын нэг
18 настай охин Т. Бор нарын зэрэг говь нутгийн
гарамгай хувьсгалч, эх орончид олон байсныг бид
мөнхөд санан дурсдаг.

МАХН-ынхаа мэргэн жолоодлого, ах дүү ЗХУ
болон социалист хамтын нөхөрлөлийн бусад
орнуудын ард түмний сэтгэл харамгүй байн-
гын тусламжийн ачаар манай говь нутгийн ард
түмэн ардын хувьсгалын жилүүдэд асар их ам-
жилтуудыг олж өргөн уудам говь нутагтаа со-
циализмыг өрнүүн байгуулж байна.

* * *

Манай аймаг БНМАУ-ын хамгийн өмнөт хяз-
гаарт орших бөгөөд газар нутгийн талаар хам-
гийн уужим, хүн амын талаар хэмгийн сийрэг тул
6,5 хавтгай дөрвөлжин км нутагт 1 хүн сууна.

Аймгийн нутаг бүхэлдээ заримдаг цөлийн бүсэнд багтах бөгөөд далайн түвшнээс дээш 1300—3000 м өндөр өргөгдсөн, нутгийн дорнод хэсэг нь талархаг, баруун хэсэг нь уулархаг. Тус аймгийн нутагт 100 гаад км үргэлжилсэн Зөөлөнгийн нуруу, Алтайн нурууны үргэлжлэл далайн түвшнээс дээш 3000-аад метр өргөгдсөн Говь Гурван сайхан уулудаас гадна Алтан уул, Нэмэгт, Гилбэнт, Тост, Сээрэй, Номгон зэрэг томоохон уулстай. Гурван сайхан уул байгалийн гоёмсог сайхан байдал, хөрс ургамлаараа хангайн вулстай төсөөтэй бөгөөд төрөл бүрийн ан амьтнаар баялаг. Жилийн дөрвөн улиралд хайлдаггүй мөст голтой. Нутгийн багахан хэсэг газрыг уулс эзлэх бөгөөд сонин сайхан элсэн уул олонтой, 200 км үргэлжилсэн Лонгорын элс, хэдэн зуун км үргэлжлэх Галба, Борзон, Заг сүүж зэрэг манай орны алдарт говиуд оршдог. Энд хэдэн арван км үргэлжлэх заг хайласан ой шугуй олонтой тохиолдоно. Ган халуунд тэсвэртэй, жижиг навчтай, шим тэжээл сайтай тачир ургамлууд ургах бөгөөд говь нутгийн ургамлын төрөл зүйл бүрэн тодорхойлогдоогүй боловч одоогоор 200 гаруй дүрсийн ургамал ургадаг гэж үздэг.

Эрс тэс уур амьсгалтай, өвөлдөө хүйтэн, зундаа халуун, жилд дунджаар 135 мм хур тундас унадаг, гол мөрөн нүүр, цөөрмөөр ховор.

Тус аймгийн нутаг 60 км-ийн цаана орших Сээрэй уулын дүрсийг тусгаж байдаг пааландсан мэт толигор өнгөт толь хад, сонин хачин хад уулс, элсэн дунд тогтсон давст нуур, тал дээрээс оргилон гарч ирсэн ихсэх буюу багасдаггүй жижиг-

хэн бүрд ус, говь нутгийн чимэг болсон баян бүрд зэрэг байгалийн үзэсгэлэнтэй газрууд олонтой. Тус аймгийн нутаг байгалийн асар их баялагтай, ан амьтнаар элбэг, 9000 кило калори дулаан өгдөг чулуун нүүрс, зэс тугалга, төмрийн хүдэр, гантиг, гөлтгөнө, барилгын чимэглэлийн чулуунууд, занар, усан ба утаат болор, перлит, хүрмэн чулуу, жонш, шохойн чулуу, төрөл бүрийн шороон будаг зэрэг ашигт малтмалуудтай. Хадат, Нэмэгт, Энгэр бүлээн зэрэг төрөл бүрийн өвчнийг анагаах чадалтай рашаан ус олонтой тохиолдоно.

Манай аймагт хар сүүлт, цагаан зээр, ирвэс, шүлүүс, үнэг, хярс, туулай, дорго, чоно зэрэг ан амьтдаас гадна дэлхийд ховордсон мазаалай хэмээх говийн бор баавгай, хулан, аргал, янгир, хавтгай (зэрлэг тэмээ) зэрэг үнэт ан, дэлхийд маш ховордсон ёл хэмээгч хүчирхэг махчин шувуу, төрөл бүрийн агнуурын шувууд элбэгтэй.

Манай аймаг 15 сумтай, нийтдээ 25 000 хүн амтай. Олонхи сумдын төв нь аймгийн төвөөсөө 100—300 км хол оршдог. Аймгийн төвийг „Даланзадгад хот“ гэж нэрлэх бөгөөд анх 1931 онд үндэслэн байгуулжээ. Энэ аймгийн анхны даргаар Улс түмний хоорондын энх тайвныг бэхжүүлэхийн төлөө олон улсын Лениний шагналт БНМАУ-ын олон нийтийн ба төрийн гарамгай зүтгэлтэн нөхөр Ж. Самбуу ажиллаж байсан юм.

ХӨДӨӨ АЖ АХУЙ

Мал аж ахуй бол тус аймгийн эдийн засгийн гол салбар бөгөөд ХАА-н 15 нэгдэл, мал аж

ахуйн 43 бригад, эрдэм шинжилгээний туршлага станц, үржил зохиомол хээлтүүлгийн улсын станц ажилладаг. Аймаг нэг сая малтай, үүнд: Тэмээ 15,4, адуу 10, үхэр 1,2, хонь 34,3, ямаа 39,1 %-ийг тус тус эзлэнэ. 1959 оны орчим тус аймагт нийтээр хоршоолох хөдөлгөөн өрнөж, улсын хэмжээгээр хамгийн түрүү нэгдэлжсэн юм. Одоо бүх малын 80 орчим хувь нь улс хоршооллын өмчинд хамрагдаж байна. Тус аймагт улсын бүх тэмээнний 4 ний 1 нь байдаг юм. Сүүлийн үеэс тус аймаг хонийг арьсны чиглэлээр каракуль үүлдрээр, ямааг ноолуур махны чиглэлээр дон хавийн үүлдрээр үржүүлж байна. Жилдээ дунджаар нэг тэмээнээс 5213 гр, хониноос 1550 гр, ямаанаас 260 гр ноолуур, 220 гр ноос, 1 ингэнээс 100 л сүү, гүүнээс 90 л сүүг тус тус авч ашигладаг. Сүүлийн таван жилд ХАА-н нэгдлүүдийн мөнгөн орлого 58 %-иар өсч үл хуваагдах фонд 2 дахин, үндсэн хөрөнгө нь 3 дахин, 1 гишүүнд олгох хөлс 3,5 дахин нэмэгдлээ. Одоогийн байдлаар төллөх бүх бог малын 60 % нь хашаагаар хангагдаж, 4-р таван жилийн эцэст нийт билчээрийн 70 % нь усаар хангагдана. Манай аймагт билчээрийг усаар хангахад зориулагдсан Усны барилга үгсралтын контор ажиллаж хөдөө аж ахуйг хөгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэж байна.

Нийт сумд малын их эмчийн тасагтай, нийт бригад малын бага эмчтэй болсны дээр аймгийн төвд нэгдсэн шинжилгээний лаборатори, эмийн сан, нэгдлүүдийг модон эдлэхүүн, хүнсний ногоогоор хангадаг нэгдэл дундын үйлдвэр ажилладаг. Хөдөө аж ахуйн байгууллагуудад нийт 100

гаруй дээд дунд мэргэжлийн эмч, зоо-техникч, агроном, гидротехникч, эдийн засагч нар ажилладаг.

ҮЙЛДВЭР

Тус аймагт улсын чанартай үйлдвэрийн салбар гэвэл жилдээ 3 сая төгрөгийн барилга барьдаг барилгын контор, нүүрсний ил уурхай ажилладаг. Түүнээс гадна ихэвчлэн орон нутгийн хөдөлмөрчдийн өргөн хэрэгцээний бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг мод, төмөр, гутал, зөөлөн оёдол, хими цэвэрлэгээ, мотоцикл засвар зэрэг тасагтай хоршооллын артель, жилд 2 сая төгрөгийн бүтээгдэхүүн гаргадаг давсны артель ажилладаг.

Аймгийн хүнсний комбинатад талх, нарийн боов, архи, саван болон бусад өргөн хэрэгцээний хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг

ТЭЭВЭР ХОЛБОО

Аймгийн гол тээвэр нь авто тээвэр бөгөөд 6 маркийн 100 шахам авто машинтай, авто тээврийн бааз жилдээ 7,5 сая тонн км-ийн ачаа эргэлт, 3 сая хүн км-ийн үүрэг гүйцэтгэдэг. Үүнээс гадна Барилгын ба Усны аж ахуйн барилга үгсралтын контор, өөртөө тээврийн хэсэгтэй. ХАА-н нэгдлүүд тус бүр 3—7 машинтай болж тээврийнхээ хэрэгцээг хангаж байгаагаас гадна ердийн хэсгийг ашиглаж байна. Аймгийн бүх сумдын 80 % нь радио станц, 20 % нь телефон харилцаатайн дээр нийт сумдад 10 ваттын хүчтэй радио узельтэй, аймгийн төвд 5 киловаттын радио станц, 500 номерын АТС ажилладаг. Манай аймаг Улаанбаатартай 7 хоног тутам онгоцоор 3 удаа, газраар 1 удаа, сумдтайгаа машинаар 3 удаа, сумнаас бригадад мотоцикл буюу морь тэмээгээр 2 удаа шуудан солилцож хэвлэл тараадаг.

Ард түмний аж амьдрал соёлын хэмжээ

Хувьсгалын жилүүдэд ард түмний аж амьдрал соёлын хэмжээ эрс дээшлэв. Урьд огт байгаагүй соёл гэгээрэл, эрүүлийг хамгаалах зэрэг олон салбарууд бий болж бэхжлээ.

Одоо сум бүр бага буюу дунд сургуультай, хүний их буюу бага эмчийн салбартай, клуб, нүүдлийн кино, номын сан, хүүхдийн цэцэрлэг, ясли, өндөр настны асрамжийн байр, жирэмсэн эмэгтэйчүүдийн амрах байр, зочид буудал, халуун ус гуанз, дэлгүүр, үсчин, зурагчин, хүнсний тасаг, цахилгаан станцтай. нийт бригадууд улаан булан, халуун ус, зочид буудал, гуанз зэрэг соёл үйлчилгээний газартай болоод байна.

Аймгийн төвд дүрслэх урлагийн салбар, орон нутгийн музей ажилладаг. Тус аймгийн насанд хүрсэн бүх хүн бичигтэн болж чадсны дээр 1000 хүн тутмаас 130 нь ямар нэг сургуульд суралцаж, 1000 хүнд нэг их эмч, 500 хүнд нэг бага эмч 10,000 хүнд эмнэлгийн 90 ор оногдож, хүн амын цэвэр өсөлт 1000 хүн тутамд 31,6 байна.

Манай аймагт 152 хүн буюу 48 өрхөд худалдааны нэг цэг үйлчилж, жилд нэг хүнд 1511 төгрөгийн бараа, түүний дотор 421 төгрөгийн хүнсний бараа, 60 орчим метр бүс бараа худалдаж байна.

Малчин айл өрхийн 80%, төв суурин газрын айл өрхүүд бүрэн радиожуулагдсан байна.

Оёдлын машин, унадаг дугуй, гэр аж ахуйн цахилгаан хэрэглэлээр хангагдсаны дээр тус аймгийн 10 өрх тутмын нэг нь мотоциклтэй болжээ.

Улсаас өндөр настан ба хөдөлмөрийн чадвараа бүр буюу түр алдагсадад зоривлж өнгөрсөн 5 жилд 2 сая гаруй төгрөгийн тэтгэвэр тэтгэмж олгосон байна. Мөн аймгийн үйлдвэрчний эвлэлийн байгууллагын харъяанд пионерийн амралт зуслан, хөдөлмөрчдийн амралтын газар ажиллаж байна.

Манай аймагт биеийн тамир спортын материаллаг бааз бэхжиж сум бригадад биеийн тамирын талбай, зарим сумдад залтай болсны дээр аймгийн төвд 5000 хүний стадион, спортын залтай болжээ.

Манай говь нутгийн хөдөлмөрчид МАХН-ынхаа 15-р их хурлын шийдвэр, 4-р таван жилийн төлөвлөгөөг амжилттай биелүүлэх зориг төгс хөдөлмөрлөж байна.

По решению правительства МНР в 1931 году был создан Южно—Гобийский аймак на основе ранее существовавших нескольких хошун, входивших в состав двух аймаков: Сайн-Ноён-Хан и Тушет-Хан.

В 1942 году образовался новый Средне-Гобийский аймак, куда перешло несколько самонов, в результате чего территория Южно-Гобийского аймака стала меньше,

До революций нынешняя территория нашего аймака размещалась на землях Хошун Чултэма бейса Сайн-Ноён-ханского аймака, Хошун Тушета Вана, Хошун Этей бейла и половина Хошуна Мэргэн вана Тушет-ханского аймака.

Народы этой территории находились в крепостной зависимости и под гнётом внешних и внутренних угнетателей, а так же были лишены элементарных человеческих прав.

Крепостной народ работал на феодалов и кроме этого платил производственные и денежные налоги.

Основное хозяйство было отсталое, кочующее животноводство, если не считать кустарных промысловиков.

Тогда не было ни какой отрасли промышленности, автотранспорта, дорог и связи.

Не было своей национальной торговли, а только существовала внешняя купеческая торговля и спекуляция.

Не было ни культурно-просветительных, ни здравоохраняющих организаций.

Было только около 60 буддийских монастырей, в которых находилось много мужского населения,

оторванного от производительного труда.

Население почти полностью было неграмотным, не считая нескольких феодалов.

Под влиянием Великой Октябрьской Социалистической революции в 1921 году победила Народная Революция Монголии, открывшая народу светлый путь к счастью и прогрессу.

Среди нас были славные сыны и дочери нашего народа, которые отдали свою жизнь в самоотверженной борьбе с внешними и внутренними врагами, такие как герой-партизан Нанзад и славная ревсомолка Т. Бор.

Народный герой Нанзад был одним из руководителей партизанского отряда в 1921 году. До конца своей жизни он боролся за укрепление народной власти и сохранение революционной Монголии.

Т. Бор была секретарем ячейки ревсомола Цогт самона нашего аймака и смело боролась с контрабандистами. В 1932 году вспыхнул мятеж против народной власти. Т. Бор. погибла в борьбе с мятежниками отдав свою жизнь за счастье монгольского народа.

Героические подвиги славных сынов и дочерей Монголии будут вечно жить в наших сердцах.

Под мудрым руководством МНРП, бескорыстной братской помощи Советского народа и стран СЭВ, наш гобийский народ в кратчайший срок достиг огромных успехов в строительстве социализма.

Наш аймак находится в зоне полупустыни и является самым южным краем Монгольской Народной Республики.

Территория нашего аймака больше других аймаков. И составляет 164,5 тыс. кв. км.

На одного человека приходится 6,5 кв. км. Средняя высота 1300--3000 метров над уровнем моря.

Рельеф местности нашего аймака разнообразный; восточная часть аймака равнинная, а западная горная.

В западной части аймака на протяжении 100 с лишним км. тянется горный хребет Зулена. Кроме этого, на территории аймака имеется много других гор: Гурван сайхан, Алтан уул, Нэмэгт, Гилбэнт, Тост, Сэврэй, Номгон.

В конце Алтайских гор расположены гора Гурван сайхан, высота которой 3000 метров над уровнем моря. Гора имеет прекрасную природу, богатую растительность, хорошую почву, много разнообразной дичи и зверей. Здесь можно увидеть огромный ледяной массив.

Есть в гобях песчанная гора Хангора, переходящая в песчаные барханы на протяжении 200 км.

На несколько сотней километров протянулись Гоби; Галба Борзан, Заг сууж и другие. Здесь есть вязовые рощи, которые тянутся десятки километров.

В гоби растут устойчивые питательные растения с маленькими листьями. Определено 200 сортов растений и много сортов еще не определено.

Климат нашего аймака резко континентальный: зима холодная, а лето жаркое. Средне годовой осадок 135 мм.

В нашем аймаке есть интересные и прекрасные места. Например; скала Толь хад имеет зеркальное отражение, в котором можно увидеть гору Сэврэй, находящуюся в 60 км.

Среди песчаных барханов есть соленые озера. На ровном месте расположены криницы с богатыми водами. Пруды, речки встречаются очень редко.

Наш аймак богат полезными ископаемыми. Имеется: каменный уголь, коллорийность которого 9000 ед., соль, железная руда, драгоценные камни, медные и свинцовые руды, в большом количестве имеются строительные материалы; прекрасный мрамор, дымчатый кварц, горный хрусталь, гипс, известняк, природные краски. Широко распространены гранит и сланцы.

В горах Хадат, Нэмэгт, Энгэр булэн есть источники минеральных вод с высоким качеством и пригодных для лечения болезней.

На территории аймака так же имеется не мало редчайших животных, представляющих большой научный интерес. Таковы: дикий осёл, хулан, дикий верблюд хабтгай, гобийский медведь, волк, рысь, заяц, лиса, барсук, корсак, козы, дзеры. Кроме этих животных есть разнообразные птицы и орёл-Бородач. Орёл Бородач очень редко встречающаяся в мире птица.

Наш аймак состоит из 15 самсов. Население аймака 25 тыс. человек. Большенство центров самсов находится на расстоянии 100—300 км от центра аймака.

Центр аймака Даланзадгад основан в 1931 году. Первым председателем аймака был Лаурезт Международной Ленинской премии за укрепление мира между народами, общественный и государственный деятель МНР тов. Жамсарангийн Самбу.

СЕЛЬСКОЕ ХОЗЯЙСТВО

Основная отрасль нашего сельского хозяйства является животноводство.

В нашем аймаке имеется 15 сельскохозяйственных объединений, 43 животноводческие бригады, научно-исследовательская станция и Государственная станция искусственного осеменения животных.

В настоящее время в аймаке имеется один миллион поголовья скота, в том числе:

Верблюдов	15,4%
Лошадей	10,0%
Коров	1,2%
Овец	34,3%
Коз	39,1%

В 1959 году были объединены в кооперативы все аратские хозяйства аймака.

В настоящее время поголовье общественного скота составляет 80% от общего поголовья скота аймака. Наш аймак имеет одну четвертую часть верблюдов, находящихся в государстве.

За последнее время мы даём большой прирост каракулевых овец и мясных пуховых коз донской породы.

В среднем за год с одного верблюда мы получаем 5213 грамм шерсти. С одной овцы получаем 1550 грамм шерсти и с одной козы 260 гр, пуха и 220 грамм волос.

Молока получаем от одной верблюдицы 100 литров, от одной лошади 90 литров, в год.

Из года в год повышается доход СХО, растут их неделимые фонды.

За последние 5 лет денежный доход СХО увеличился на 58 %, неделимый фонд в три раза и основной фонды так же в три раза.

Оплата трудодня увеличилась в 3,5 раза. 60 % поголовья скота обеспечено теплыми помещениями. В конце четвертой пятилетки будет обеспечено водой 70 % пастбищ всей территории нашего аймака.

В нашем аймаке есть стройтельно-монтажная контора по водообеспечению населения и обводнению пастбищ. Эта контора выполняет большую задачу для подъёма и развития сельского хозяйства.

В каждом самоне имеется ветучасток, а в каждой бригаде имеется ветфельдшер. В центре аймака есть объединённая исследовательская лаборатория и аптека.

Есть в нашем аймаке межобъединенческое предприятие по заготовке и обработке лесоматериалов и овощей для снабжения объединений.

В СХО работает больше 100 специалистов с высшим и средним образованием. Это; ветврачи, ветфельдшеры, зоотехники, агрономы, гидротехники и экономисты.

ПРОМЫШЛЕННОСТЬ

В нашем аймаке есть строительная контора, выполняющая за год строительно-монтажных работ на 3 миллиона тугриков.

Имеется угольная шахта.

Имеется кооперативная артель с отделениями; металлообрабатывающим, деревообрабатывающим, пошивочные изделия, изготовление обуви, а также химчистка и ремонт мотоциклов, принадлежащих населению аймака.

Работает промысел по добыче соли, производящий продукции в год на 2 миллиона тугриков.


Пищевой комбинат производит необходимую для населения продукцию; кондитерские изделия, спиртные напитки, мыло.

ТРАНСПОРТ И СВЯЗЬ

Основной вид транспорта нашего аймака - автомобильный.

Автобаза имеет 6 марок автомобилей с общим числом автомобилей около 100 штук. Грузооборот автобазы - 7,5 миллионов тонно-километров, пассажиро-оборотов 3 миллиона человеко-километров в год. Кроме автобазы в каждой СХО имеется 3—7 автомашин.

23890



Водная и строительная конторы имеют свой автогаражи 80 % самонов имеют радиостанции, 20% имеют телефонную связь и в каждом самоне есть радиоузел мощностью в 100 ватт для трансляции передач населению.

В центре аймака работает радиостанция мощностью в 5 квт, и автоматическая телефонная станция на 500 номеров.

Почта из Улан-Батора в Даланзадгад доставляется 3 раза в неделю самолётом и 1 раз в неделю автомашиной. С центра аймака в самоны почта доставляется 3 раза автомашинами, а из самонов в бригады 2 раза мотоциклами или лошадьми и верблюдами.

06070

Культурное благосостояние народа

За время народной власти очень быстро повысился материальный и культурный уровень трудящихся аймака.

В настоящее время у нас есть широко развитое здравоохранение. Имеются: больницы, роддомы и амбулатории, чего дореволюции не было.

Каждый самон имеет начальную или среднюю школу, врачебный пункт, клуб с киноустановкой, библиотеку, детсад, ясли, дом для престарелых, дом отдыха ретери и ребёнка, гостиницу, баню, столовую, магазины, пищевые отделения, электростанцию, а в некоторых самонах ещё имеется парикмахерская и фотоателье.

В каждой бригаде организовано бытовое обслуживание, имеется красный уголок, столовая, гостиница.

В центре аймака есть Краеведческий музей, отделение изобразительного искусства. Всё взрослое население владеет письменностью. Из каждой 1000 человек 130 учится в школе.

На 1000 человек приходится один врач и на 500 человек один фельдшер. На 10000 человек населения приходится 90 больничных коек.

Один торговый участок обслуживает 152 человека или 48 семей. За год один человек покупает товара на 1511 тугриков, из них 421 тугрик расходуется на продукты питания. Один человек приобретает 60 м материала в год.

Жители центра самона полностью имеют радио, а 80% жителей худонов имеют радиоприёмники.

Население обеспечивается (по запросам) швейными машинами, велосипедами, домашними гарнитурами.

В аймаке из 10 семей одна семья имеет мотоцикл.

За последние 5 лет пенсионеры и инвалиды трудящиеся престарелого возраста аймака получили больше 2-х миллионов тугриков из средств профсоюзных организаций.

В ведении профсоюзной организации имеется пионерский лагерь и дом отдыха,

В нашем аймаке большое внимание уделяется развитию спорта.

Каждая бригада и самон имеет спортивную площадку, а некоторые самоны имеют спортивные залы.

В центре аймака есть спортзал и стадион на 5000 мест.

* *
* *

* *
* *

* *
* *

Трудящиеся Южно—Гобийского аймака успешно претворяют в жизнь решения XV съезда МНРП и борются за выполнение четвертого пятилетнего плана.

„Говийн мэдээ“ сонины
СХ-ийн үйлдвэрт 1500 ширхэг
хэвлэв.